*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны*
*98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.ОЮУНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин /2023 оны байдлаар/ | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Тамгын газрын хэлтэс, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ №1.1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тооцож ажиллах | Хэрэгжилтийн хувь | 96.0 хувь | 97.0 хувь | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилт урьдчилсан гүйцэтгэлээр 2024 оны 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна. | 2024.01<br>2024.12 | 100<br>70 |
| 2. | Арга хэмжээ №1.2. Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож ажиллах | Хэрэгжилтийн хувь | 96.80 хувь | 98.0 хувь | Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож ажиллаж байна.<br>59 зорилт, 102 заалт бүхий төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилд 72.0 хувьтай, жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 98 хувьтай байна. | 2024.01<br>2024.12 | 100<br>70 |
| 3. | Арга хэмжээ №1.3. | Хэрэгжилтийн хувь | 87.0 хувь | 100 хувь | “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2024 онд 4 зорилтын | 2024.01<br>2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | /Өссөн дүнгээр/ | | | хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.<br>Үүнд:<br>- Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд багуудын ажлын байрыг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байгаа ба улсын төсвийн нийт 8.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Говил, Баянцагаан, Яргуйт, Зэст багуудын цогцолбор төвийг ашиглалтанд хүлээн авсан. 2021-2024 онд орон нутгийн төсвийн 96.6 сая төгрөгөөр багийн байруудад урсгал засвар, 320.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багийг суурин болон зөөврийн компьютер, 3 үйлдэлт болон өнгөт принтер, лед дэлгэц гэх мэт техник тоног төхөөрөмж, шаардлагатай эд хогшлуудаар хангасан.<br>Багийн 130 гаруй хэсгийн ахлагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг сайжруулах чиглэлээр орон нутгийн төсвөөс харилцаа холбоо, бичиг хэргийн зардалд 2021-2024 онд нийт 128.6 сая /өссөн дүнгээр/ төгрөг зарцуулсан. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор баг бүр нутаг дэвсгэрээ хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 232.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, мөнгөн тусламж олгох, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, орон гэр, хашааны газар олгох зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.<br>Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх боломж олгох зорилгоор орон нутгийн төсвийн 58.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 29 багт "Иргэний цахим булан"-г байгуулан үйл ажиллагааг тогтворжуууллаа.<br>Багийн үйл ажиллагаанд иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд баг, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэж ажиллаж байна. | | |
| 4. | Арга хэмжээ №1.4. Сумдын Засаг даргын үйл ажиллагааны | Хэрэгжилтийн хувь | Баян-Өндөр сум 86.0 хувь, | Хэрэгжилтийн хувь өссөн байх | Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны | 2024.01<br>2024.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах | | Жаргалант сум 90.0 хувь | | хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаанд нь арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Баян-Өндөр сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 96.0 гаруй хувьтай, Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явц 98.0 хувьтай хэрэгжсэн байна. | | 70 |
| **Зорилт-2: Тамгын газрын дотоод ажлыг гүйцэтгэх, нэгжийн ажлын уялдаа холбоог хангах** | | | | | | | |
| 5. | Арга хэмжээ № 2.1. Аймгийн Засаг даргын захирамжийг албажуулан бүртгэж, заавар журмын дагуу хадгалах | Холбогдох дүрэм зааврын хэрэгжилт | 929 захирамжийг журмын дагуу бүртгэсэн. | Холбогдох журам, зааврын дагуу бүртгэлжүүлж хадгална | 2024 оны 12 сарын 04-ний өдрийн байдлаар аймгийн Засаг даргын зохион байгуулалтын 900 гаруй, хүний нөөцийн 42 захирамжийг холбогдох журмын дагуу албажуулан бүртгэсэн. | 2024.01 2024.12 | 100 70 |
| 6. | Арга хэмжээ № 2.2. Хөрөнгө, санхүүтэй холбоотой захирамжуудыг Шилэн дансанд хугацаанд нь байршуулах | Холбогдох хуулийн хэрэгжилт | Нийт 624 захирамжийг сар бүрийн 06-ны дотор байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангасан. | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана | 2024 оны 12 сарын 04-ний байдлаар хөрөнгө санхүүтэй холбоотой 651 захирамжийг Шилэн дансанд хуулийн хугацаанд нь байршуулан ажиллаж байна. | 2024.01 2024.12 | 100 70 |
| 7. | Арга хэмжээ № 2.3. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангаж зохион байгуулж ажиллах | Төлөвлөгөөний дагуу | 24 | Гүйцэтгэлээр | Засаг даргын зөвлөлийн хурлыг төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулж, 25 удаагийн хурлаар 111 асуудлыг хэлэлцэж, уг асуудлуудтай холбогдуулан холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч ажиллалаа. | 2024.01 2024.12 | 100 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Арга хэмжээ № 2.4. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналд тодорхойлогдсон иргэдийн материалыг хүлээн авч хянан шийдвэр гаргуулах, шагнал гардуулах асуудлыг хариуцан зохион байгуулах | Холбогдох дүрэм, журмын хэрэгжилт | Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын болон бусад хууль, журмыг мөрдөж ажилласан | Шагналын журмыг мөрдөж ажиллах | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам болон Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журмын дагуу шагналд тодорхойлогдсон 2000 гаруй иргэдийн материалыг хүлээн авч судлан, 470 иргэнийг Орхон аймгийн Хүндэт тэмдгээр, 1400 гаруй иргэнийг аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнаж урамшуулсан. | 2024.01<br>2024.12 | 100<br>70 |
| | **Зорилт-3: "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | | |
| 9. | Арга хэмжээ № 3.1. Аймгийн Засаг даргын тамгыг түших, хадгалалт хамгаалалтыг хариуцаж ажиллах | Холбогдох хууль, тогтоомжийн мөрдөж ажилласан байдал | Холбогдох хууль, журмын дагуу ажилласан | Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллана | Аймгийн ЗДТГ-ын даргын 2016 оны А/50 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын тамгыг Тамга тэмдэг хэрэглэх заавар, журмын дагуу түших ажлыг хариуцан ажиллаж байна. | 2024.01<br>2024.12 | 100<br>70 |
| 10. | Арга хэмжээ № 3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу баримт бичгийг хөтөлж, хөтлөгдөж дууссан бичиг хэргийг цэгцэлж байгууллагын архивт шилжүүлэх | Архивт шилжүүлэх баримтын тоо, стандарт хангалт | 30 боть баримтыг стандартын дагуу хөтөлж, архивт шилжүүлсэн | Гүйцэтгэлээр | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246-р тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу баримт бичгийг хөтөлж, 3 сард өмнөх онд хөтлөгдөж дууссан 34 боть баримтыг архивт хүлээлгэн өгсөн. | 2024.01<br>2024.06 | 100<br>70 |
| 11. | Арга хэмжээ № 3.3. Өөрийн эрхэлж буй ажилд хамааралтай тогтоол шийдвэрүүдийг хяналтандаа авч, биелэлтүүдийг тооцож ажиллах | Хяналтанд авах тогтоол шийдвэрийн тоо | 3 | 4 | Өөрийн эрхэлж буй ажилд хамааралтай 13 дүрэм, журмыг тогтмол мөрдөж ажиллахын зэрэгцээ шинээр гарсан УИХ болон Засгийн газрын тогтоол шийдвэрүүд, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, ИТХ-ын тогтоол шийдвэр гэх мэт 7 баримт бичгийг хяналтандаа авч биелэлтүүдийг хугацаанд нь гаргаж | 2024.01<br>2024.12 | 100<br>70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох газруудад нь хүргүүлж ажиллаж байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Аймгийн Засаг даргын болон Тамгын газрын даргын шийдвэрээр Ажлын хэсэгт ажиллах | Үүрэг даалгаврын хэрэгжилт | 4 удаагийн арга хэмжээнд тухай бүрт оролцож ажилласан | Тухай бүрт хэрэгжүүлж ажиллана | ЗДТГ-ын даргын шийдвэрээр шагнал, ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдэд 8 удаа оролцож ажилласан ба ЗДТГ-ын Баримт нягтлан шалгах комиссын ажлыг гүйцэтгэж байна. | 2024.01 2024.12 | 100 70 |
| 2. | Арга хэмжээ 2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон хугацаатай албан бичгийн хариуг өгч ажиллах | Шийдвэрлэлтийн хувь | 100 хувь | 100 хувь | Иргэдээс ирүүлсэн нийт 6 өргөдөл, гомдол болон 68 албан бичиг, үүрэг даалгаврын хариуг тухай бүрт өгч, 100 хувь шийдвэрлэж ажиллалаа. | 2024.01 2024.12 | 100 70 |
| 3. | Арга хэмжээ 3. Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, хоцорч буй ажлуудыг эрчимжүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор удирдлагаас өгч буй үүрэг даалгавруудыг хугацаанд нь гүйцэтгэх | Үүрэг даалгаврын хэрэгжилт | Тухай бүрт хугацаанд нь гүйцэтгэсэн | Тухай бүрт хугацаанд нь гүйцэтгэх | Аймгийн ИТХ болон Засаг дарга, дээд шатны удирдлагуудаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг тухай бүрт хугацаанд нь бүрэн гүйцэтгэж ирсэн. | 2024.01 2024.12 | 100 70 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ №1.1. Төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах | Хамрагдсан тоо | 9 | Гүйцэтгэлээр | Салбарын болон орон нутгийн хурал, захиргааны байгууллагаас зохион байгуулж буй сургалт, зөвлөгөөнд тогтмол оролцож байна. Тухайлбал: Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээрх  Пүрэв гаригийн цахим сургалтууд болон бусад ажлын байран дахь сургалтуудад хамрагдлаа. | 2024.01<br>2024.12 | 100<br>15 |
| 2. | Арга хэмжээ №1.2.<br>Албан ажлын шаардлагын дагуу компьютерийн өргөн хэрэглээний программуудыг шинээр эзэмших | Шинээр эзэмшсэн программ | Word, Excel, PowerPoint, MovieMaker | Publisher программыг эзэмших | Компьютерийн Publisher программыг бие даан эзэмшиж албан хэрэгцээндээ ашиглаж эхэлж байна. | 2024.01<br>2024.12 | 100<br>15 |

ТАЙЛАН ГАРГАСАН: ТЗУХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: Ч.ОЮУНБИЛЭГ